



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 4/694

Алтай хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.1 дэх зорилт, 2.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд “Хантайшир-100” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:Ш.Насан  
Гишүүдэд: П.Хулан

(аймгийн Засаг даргын зөвлөх)  
(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

С.Мөнхжаргал

(Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Г.Хурцгэрэл

(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Т.Эрхэмбаяр

(“Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төв” УТҮГ-ын захирал)

Ж.Амгаланбаатар

(Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Т.Баярзул

(Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

2.Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, ажлыг үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг (Ш.Насан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

